

СОЁМБО МЭДЭЭ

ҮЙЛ ЯВДАЛ

САЙДЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА

Батлан хамгаалахын сайдын зөвлөл өнгөрсөн мягмар гарагт хуралдлаа. Уг хуралдаанаар “Батлан хамгаалахын гадаад харилцааг 2030 он хүртэл хөгжүүлэхэд баримтлах бодлого”, “Батлан хамгаалахын ёслолын журам”-ыг тус тус шинэчлэн баталсан юм. Эдгээр баримт бичгийг баталснаар батлан хамгаалахын гадаад харилцааны цаашдын чиг хандлагыг тодорхойлох, батлан хамгаалах, Зэвсэгт хүчний гадаад, дотоод ёслолын арга хэмжээг зохион байгуулах дэг жаяг, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх зүйн чухал ач холбогдолтой.

Монгол Улсын батлан хамгаалахын гадаад харилцааг хөгжүүлэхэд баримтлах бодлого нь хөрш болон бусад орнуудтай харилцан ойлголцол, цэргийн итгэлцэл, нөхөрлөлийг бэхжүүлэх, Монгол Улсын цэргийн байгуулалтыг төгөлдөржүүлэх, Зэвсэгт хүчнийг шинэчлэх, бэхжүүлэх зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэх бөгөөд гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангах, залгамж чанарыг хадгалах, энхийг эрхэмлэх зарчмыг баримтлахыг дээрх бодлогын баримт бичигт тусгалаа.

Мөн Зэвсэгт хүчний сэтгэл зүйн хангалтын өнөөгийн байдал, тулгамдсан асуудлын талаар хэлэлцэн тодорхой шийдвэрүүдийг гаргасан юм.



САЛАА, ТАСГИЙН ЗАХИРАГЧ НАРЫН МЭРГЭШҮҮЛЭХ СУРГАЛТ АМЖИЛТТАЙ ЯВАГДАЖ ӨНДӨРЛӨВ



Зэвсэгт хүчний Жанжин штабаас Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын салаа, тасгийн захирагч нарын мэргэшүүлэх сургалтыг таван хоногийн хугацаанд Хужир буланд байрлах Сургалтын төвд зохион байгууллаа. Сургалтаар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын 250 гаруй цэргийн алба хаагч 18 цагийн онол, 42 цагийн дадлагыг хээрийн нөхцөлд явуулсан юм. “Санаачилгатай, сахилгатай, сурлагаар манлайлагч байх нь” уриалга дор цэргийн өдөр тутмын үйл ажиллагааг Цэргийн дотоод албаны дүрэм, зааврын дагуу удирдан явуулах, сургалт, бэлтгэлийн анхан шатны баримт

бичгүүдийг боловсруулах, тэдгээрийг хэрэгжүүлэх, салаа, тасаг, тооттой явуулах хоногийн хичээлийн бэлтгэлийг хангуулах, буудлагыг удирдах зэрэгт оролцогчдыг сурган дадлагажуулахад сургалтын зорилго оршиж байгаа юм.

Сургалтын хаалтын арга хэмжээнд ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар нар оролцож “Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, өнгө төрх, нэр хүнд өөрөөс тань хамаарч байгаа” гэдгийг сайтар ухамсарлаж, албандаа илүү бүтээлч, санаачилгатай ажиллахыг захиад “Талархал” гардууллаа.

ЦАХИМ СУРГАЛТ БОЛЛО

Батлан хамгаалах яамны ХШУДАГ-аас “Батлан хамгаалахын салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг танилцуулах цахим сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтад ЗХЖШ, яамны бүтцийн нэгжүүд, харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллагуудын төлөөлөл, тайлан, мэдээ, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан тушаалтнууд хамрагдав.

Батлан хамгаалах яамны болон Зэвсэгт хүчний хяналт, шалгалтын нэгжүүдийн үйл ажиллагааны уялдааг хангахын тулд “Батлан хамгаалахын нэгдмэл хяналт” бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Энэ бодлогын хүрээнд ХШУДАГ “Батлан хамгаалахын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, “Батлан хамгаалахын дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын журам”-ыг тус тус боловсруулан батлуулсан байна. Эдгээр журмаар оны эхэнд төсвийн ерөнхийлөн захирагчийн 89 байгууллагын 250 гаруй алба хаагчдад сургалт зохион байгуулсан гэдгийг ХШУДАГ-ын дарга, хурандаа Б.Эрхэмбаяр онцолсон юм.

Мөн тэрээр “Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдан мөрдөгдөж байсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын өнгөрсөн оны 12 дугаар сард шинэчилж, Засгийн газрын 206 дугаар тогтоолоор баталсан. Өнөөдрийн сургалтаар энэхүү нийтлэг журамд

нийцүүлэн боловсруулж батлуулсан “Батлан хамгаалах салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг та бүхэнд танилцуулж, мэдээлэл солилцох юм” гэв.

Түүнчлэн ХШУДАГ-ын ахлах мэргэжилтэн Н.Баттөр “Батлан хамгаалах салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ын танилцуулж, гол ойлголтуудыг цаглаврын хамт тайлбарласан.

Хяналт шинжилгээ үнэлгээ хийх давтамжийг нэмэгдүүлсэн, хэрэгжилтийг тайлагнах баримт, бичиг, хугацааг тодорхой болгосон, тайлан, мэдээг албажуулж ирүүлэх талаар болон яамны харьяа байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж байх зэргийг тодорхой тусгаж өгсөн нь энэхүү аргачлалын онцлог аж.

Үүний дараа тайлан, мэдээнд гарч буй нийтлэг дутагдлууд, цаашид анхаарах асуудлуудын талаар хэлэлцэн, санал бодлоо солилцоогов.

Сургалтын төгсгөлд хурандаа Б.Эрхэмбаяр бие бүрэлдэхүүнд ажлын уялдаа холбоо, хууль тогтоомж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг хангах, түүндээ үнэлгээ хийж хэвших мөн Батлан хамгаалахын сайдын гаргасан “Хандлагаа өөрчилж, хариуцлага нэмэгдүүлэе” уриалгын дагуу цэргийн албан хаагч, албан тушаалтнууд дор бүрнээ сайтар анхаарч ажиллахыг үүрэг болгов.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|------|
| ☀️ 25 | 🌧️ 9 |

ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 33 | 🌧️ 23 |

АФГАНИСТАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 25 | 🌧️ 12 |

ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ | ЗАРАХ |
|--------|----------|----------|
| USD 🇺🇸 | 2.844.00 | 2.855.00 |
| EUR 🇪🇺 | 3.441.00 | 3.501.00 |
| CNY 🇨🇳 | 441.00 | 444.40 |
| RUB 🇷🇺 | 38.10 | 39.70 |
| JPY 🇯🇵 | 25.80 | 26.30 |
| KRW 🇰🇷 | 2.43 | 2.56 |

ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 08
2021.05.20.
/ЛҮРЭВ ГАРАГ/

ЗУНЫ ТЭРГҮҮН ХАРАГЧИН МОГОЙ САРЫН ГУРВАН ХӨХ ШАХ ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Нас уртасна.

Наран ургах, шингэх:
05.08-20.30

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Мунхарахуй

Суудал:

Үс.

Аргын тооллын 5 сарын 20, Бархасвадь гараг. Билгийн тооллын 8, Бага морь одтой, шар луу өдөр. Өдрийн наран 5 цаг 08 минутад мандан, 20 цаг 30 минутад жаргана. Тухайн өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, лус тахиx, хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн эмсэг урлах, дархны үйлд сайн. Гүүр тавих, газар ухах, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одоосод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлэх буюу засуулбал нас уртадна.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

| | | |
|----------------------------|--------------------|----------------------|
| НИЙТ БҮРТГЭГДСЭН 50.099 | ЭДГЭРСЭН 43.586 | НАС БАРСАН 227/12 |
|----------------------------|--------------------|----------------------|

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

| | | |
|------------------------------|----------------------------|------------------|
| НИЙТ БАТЛАГДСАН 2342 (30) | ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 220 | ЭДГЭРСЭН 2092 |
|------------------------------|----------------------------|------------------|

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

| |
|--------------------------------|
| Тохиолдол Нийт: 163,312,429 |
| Эдгэрсэн Нийт: 138,292,579 |
| Нас барсан Нийт: 3,386,825 |

Шинэ Коронавирусийн ! Эсрэг ХАМТДАА !

- ✓ Гараа тогтмол савандаж угаах
 - ✓ Амны хаалт тогтмол зүүх
 - ✓ Өвчлөл гарсан улс оронд очихгүй, зочин урихгүй байх
- ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ЦАХИМ ШУУДАНД

ТҮВШИН ТОГТООХ ҮЗЛЭГ ЭНЭ САРЫН 24-НД ЭХЭЛНЭ



Зэвсэгт хүчний офицер, ахлагч нарын түвшин тогтоох үзлэгийг энэ сарын 24-ний өдрөөс эхлэн зохион байгуулж явуулахтай холбоотойгоор ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар өчигдөр Төрлийн цэргийн командлалууд, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын удирдлагуудтай цахимаар уулзаж, тодорхой үүрэг, чиглэлийг өглөө.

Тэрээр түвшин тогтоох үзлэгт ороход бэлтгэл ажлыг бүрэн хангаж, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлсэн байхад Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын захирагч нар анхаарахыг захиж, офицер, ахлагчаа 100 хувь бүрэн хамруулах ёстойг онцлолоо. Мөн тэрээр цэргийн алба, сахилга хариуцлага нэмэгдүүлэхэд алхам тутамдаа анхаарч, үр дүн гарах шаардлагатай байгааг дурдсан юм.

Түвшин тогтоох үзлэг нь ажлын гүйцэтгэл, үр дүн, албаны хандлага, мэргэжлийн түвшин, сахилга, ёс зүйн төлөвшил, бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийн байдал, сэтгэл зүйн байдал зэрэг таван чиглэлийн хүрээнд явагдана. Үзлэг нь офицер, ахлагчийн мэргэшил, үр чадвар, албан тушаалын гүйцэтгэл,

сахилга хариуцлага, ёс зүйн хэм хэмжээ, эрүүл мэндийн зэрэглэл, бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшин тогтоох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, цэргийн алба хаагчдын ёс зүйн төлөвшил, албандаа хандах хандлага, нийгэмд эзлэх байр суурь, манлайллыг нэмэгдүүлэх зорилготой юм.

Үзлэг энэ сарын 24-ний өдрөөс Улаанбаатар цэргийн хүрээний ангиудаас эхэлж, 8 дугаар сарын сүүл үе хүртэл үргэлжилнэ. Ингэхдээ ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, Барилга-Инженерийн цэргийн удирдах газар, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарууд болон бүтээн байгуулалтын ангиудын офицер, ахлагч нар бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдах юм.

Түвшин тогтоох үзлэгийн ажлын хэсгийн даргаар ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга, бригадын генерал Ц.Жавхланбаатар, нарийн бичгийн даргаар ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантулга нар ажиллаж байна.

Ахлах дэслэгч Д.БОЛОРМАА

ТАКТИКИЙН ХЭЭРИЙН СУРГУУЛИАР ...

Зэвсэгт хүчний 256 дугаар анги

2020-2021 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу хээрийн гаралт, полигоны дадлага, байлдааны буудлагатай ротын тактикийн хээрийн сургуулийг "Хүч нэмэгдүүлсэн танкийн рот давшилтад" сэдвээр амжилттай зохион байгууллаа. Байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийн зорилго, зорилтыг бүрэн дүүрэн биелүүлж танк, мотобуудлага, артиллер, миномёт, зенитийн салбарууд амжилттай оролцов. Энэ удаагийн тактикийн хээрийн сургуулиар Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 113 дугаар тусгай салбарын 2 тоотыг сурган дадлагажуулахын зэрэгцээ ангийн 40 гаруй хугацаат цэргийн алба хаагчийг бие даалгаж "Т-55" танкаар буудлага хийлгэсэн нь онцлог болсон юм.

Хошууч Л.АМАРБАЯСГАЛАН



МОД ТАРЬЖ-НАС НЭМБЕ



Зэвсэгт хүчний 013 дугаар анги

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан ангийн байрлал, холбооны сургалтын төвийн районд цэргийн алба хаагчид, алба, салбарууд 650 ширхэг чацаргана, үхрийн нүд зэрэг жимс, жимсгэнийн бут, 350 ширхэг, бургас, улиас модыг тарих ажлыг зохион байгууллаа.

Энэхүү ажил, арга хэмжээг "Нэг цэргийн алба хаагч-Нэг мод" тарих уриан дор зохион байгуулсан нь бие бүрэлдэхүүний ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, эко орчныг бий болгох, агаарын бохирдлыг бууруулахад онцгой ач холбогдолтой арга хэмжээ боллоо.

Хошууч С.БАТБААТАР

ХОВДЫН ХОРООНООС ДАЙЧДЫНХАА АР ГЭРТ ДУРСГАЛЫН ЗУРАГ, ЗАХИДЛЫН ХАМТ ХҮРГҮҮЛЭВ

Зэвсэгт хүчний 123 дугаар анги

Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан хугацаат цэргийн алба хаагчдыг ар гэрийнхэнтэй нь цахимаар холбох ажлыг тодорхой хугацааны давтамжтайгаар зохион байгуулсаар байна. Энэ удаад Зэвсэгт хүчний 123 дугаар ангиас "Монгол шуудан" ТӨК-тай хамтран хугацаат цэргийн алба хаагчдынхаа аав, ээж, ахан дүүс, найз нөхдөдөө бичсэн захидлыг, гэрэл зургийн хамт хүргүүлээ. Мөн орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан албаа үлгэр жишээ хаж байгаа 15 хугацаат цэргийн

алба хаагчийн ар гэрийнхэнд ангийн захирагчаас талархлын захидлыг хүргүүлэв.

Түүнчлэн ангийн Соёл хүмүүжлийн алба, Мотобуудлагын батальон хамтран хугацаат цэргийн дайчдынхаа дунд "Монгол бичгээр хэн цэвэр сайхан бичих вэ" уралдааныг зохион байгуулахад байлдагч Э.Жамъянсүрэн, Г.Буянтүшиг нар тэргүүлээ. Ховд аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан "Эх хэл бидний бахархал" аяны хүрээнд "Уран бичлэг", "Бүтээлч уралдаан-2021"-д манай ангийн зарим цэргийн алба хаагч, хугацаат албаны дайчид амжилттай оролцсон юм.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ



Дэлхийн хэмжил зүйн өдөр 2021.05.20

ХЭМЖИЛ ЗҮЙ ТАНЫ ӨДӨР ТУТМЫН АМЬДРАЛД...

Дэлхийн хэмжил зүйн өдрийг 1875 онд Франц Улсын Парис хотод Метрийн конвенц (Олон улсын шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны анхны гэрээ) анх батлагдсан өдрөөс хойш жил бүрийн 5 дугаар сарын 20-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлсээр иржээ. Энэхүү гэрээ нь дэлхий дахины хувьд хэмжлийн нэг ойлголт, нэгдсэн тогтолцоотой болох суурийг тавьсан байна. 2021 оны

хэсэг болж, түүндээ юу ч бодолгүй итгэж, найддаг болсныг анзаарах сөхөөгүй байдаг. Хэдийгээр орчин үеийн технологи нь бидний амьдралд чухал үүрэг гүйцэтгэж байгаа ч, тэдгээрийн хэмжлийн нарийвчлал, найдвартай байдлыг хангахын тулд хэмжих хэрэгслийг нь үргэлж сайжруулж байх нь зүйтэй юм.

Хүмүүсийн дунд энэ бүхний ард хэмжлийн нарийвчлал ба тэдгээрийн үнэн зөв байдалд Олон



хувьд тус өдрийг тохиолдуулан "Эрүүл мэндийн салбар дахь хэмжил зүй" сэдвээр цахим семинар, хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа.

Монгол Улс нь Олон улсын хэмжлийн нэгжийн Метрийн системд 1944 онд анх шилжсэнээр дэлхийн бусад улс оронтой худалдаа, аж үйлдвэр, шинэ техник, технологийн салбарт хамтран ажиллах, нэгдсэн ойлголттой болох, эдийн засгийн хувьд ч үр ашигтай, хэмнэлттэй үйл ажиллагаа явуулах боломж бүрджээ.

Бидний нүдэнд төдийлөн харагдаж, ажиглагдахгүй юм шиг боловч өдөр тутмын амьдралд үргэлж тааралддаг зүйлсийн нэг нь хэмжил зүй буюу хэмжил юм. Та өөрөө ч мэдэлгүйгээр өглөө босоод цагаа харахдаа цаг хугацааг хэмжиж, эсхүл дэлгүүрээс хүнсний бүтээгдэхүүн цуглуулахдаа тэдгээрийн жинг нь хэмжиж, машиндаа бензин, түлш хийхдээ-эзэлхүүн, багтаамжийг нь хэмжиж, цусны даралтаа шалгах-даралт хэмжиж байдаг. Эдгээрийн хэмжлийн үр дүнгээс хамаарч бид нар аливаа шийдвэрийг гаргадаг ба шууд утгаар нь ослоос сэргийлж, хурдаа тохируулж машиныхаа хааз, торомз дээр гишгэх эсхүл хэрэв таны цусан дахь сахрын хэмжээ их бол чихэрлэг хүнс хэрэглэхээ багасгах гэх мэт үйлдлийг өдөр тутамдаа хийдэг.

Өдөр тутмын амьдралд тохиолддог эдгээр зүйлс нь төрөл бүрийн хэмжлийг шаарддаг. Орчин үеийн техник, технологийн хөгжилтэй зэрэгцэн хэмжлийн нарийвчлал ихсэж, хүний нүдэнд анзаарагдахгүй хэмжээнд хүртлээ хөгжиж байна.

Заримдаа бид өөрсдөө ч мэдэлгүйгээр хэмжил гэдэг зүйл хүний амьдралын салшгүй нэг

улсын болон үндэсний хэмжил зүйн мэргэжлийн байгууллага хэмжлийн тухай шинжлэх ухаанд тулгуурлан үргэлж хяналт тавьж, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалж байдгийг мэддэггүй.

Дэлхийн улс орнуудад үндэсний хэмжил зүйн байгууллага нь ямар ч хүнд хэцүү нөхцөлд хэмжлийн шинэ арга, аргачлалыг туршиж, боловсруулах замаар хэмжлийн тухай шинжлэх ухааныг улам боловсронгуй болгох чиглэлд үйл ажиллагаа явуулдаг. Дэлхийн хэмжээнд хэмжлийн үр дүнгийн үнэн зөв, итгэлтэй байдлыг хангах зорилготой BIPM буюу Олон улсын Жин, хэмжүүрийн товчоотой улс орон болгоны хэмжил зүйн мэргэжлийн байгууллага хамтарч ажилладаг. Манай улсын хувьд энэ байгууллага нь Стандарт хэмжил зүйн газар юм. Зэвсэгт хүчний хэмжээнд Зэвсэгт хүчний Нэгдсэн лабораторийн Хэмжил зүйн лаборатори нь улсын итгэмжлэлийн хүрээнд хэмжих хэрэгслийн шалгалт, тохируулга, баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулдаг.

Аливаа улсын бараа бүтээгдэхүүнийг хэмжихэд ашиглагддаг жин, хүрээлэн буй орчны бохирдлыг хэмжих хэрэгсэл, эрчим хүчний зарцуулалтыг хэмжих тоолуурууд нь хууль, эрх зүйн зохицуулалт, хяналтад тогтмол байдаг. OIML буюу хууль эрхийн хэмжил зүйн олон улсын байгууллага нь дээрх төрлийн хэмжих хэрэгслүүдийн загварыг баталж, гэрчилгээ олгодог ба манай улсад тэдгээрт загварын туршилт давтан хийхгүйгээр ашиглаж болдог байна.

ЗХЖШ-ЫН МТГ-ЫН ХЭМЖИЛ ЗҮЙН АЛБАНЫ МЭРГЭЖИЛТЭН АХМАД Б.ЦОГЖАРГАЛ